



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
СТАТИСТИКИЙН МЭДЭЭ
2024 оны 7 дугаар сар**

/УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛЭЭР/

Улаанбаатар хот,
2024 оны 08 сарын 05

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ.....	4
1.1. Ачаа тээвэр.....	5
1.2. Зорчигч тээвэр.....	6
БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР.....	7
2.1. Ачаа тээвэр.....	7
2.1.1. Экспортын ачаа, боомтоор.....	8
2.1.2. Импортын ачаа, боомтоор.....	9
2.1.3. Ачааны нэр төрөл.....	10
2.1.4. Ачаа эргэлт, боомтоор.....	10
2.2. Зорчигч тээвэр.....	11
2.3. Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	11
БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР	13
3.1. Ачаа тээвэр.....	13
3.2. Зорчигч тээвэр.....	15
БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР	17
4.1. Ачаа тээвэр.....	17
4.2. Зорчигч тээвэр.....	18
4.2.2. Олон улсын зорчигч тээвэр.....	19
4.2.3. Орон нутгийн зорчигч тээвэр.....	20
4.3. Нислэг гүйцэтгэлийн мэдээ.....	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	4
Хүснэгт 2. Автотээврийн ачаа.....	7
Хүснэгт 3. Автотээврийн ачааны экспорт, боомтоор.....	8
Хүснэгт 4. Автотээврийн ачааны импорт, боомтоор.....	9
Хүснэгт 5. Автотээврээр тээсэн ачааны нэр төрөл.....	10
Хүснэгт 6. Ачаа эргэлт, боомтоор.....	10
Хүснэгт 7. Автотээврийн зорчигч тээвэр.....	11
Хүснэгт 8. Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	11
Хүснэгт 9. Төмөр замын ачаа тээвэр.....	13
Хүснэгт 10. Төмөр замын зорчигч тээвэр.....	15
Хүснэгт 11. Агаарын тээврийн ачаа.....	17
Хүснэгт 12. Агаарын тээврийн зорчигч.....	18
Хүснэгт 13. Олон улсын зорчигч тээвэр.....	19
Хүснэгт 14. Орон нутгийн зорчигч тээвэр.....	20
Хүснэгт 15. Нислэг гүйцэтгэлийн мэдээ.....	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	5
Зураг 2. Нийт экспорт.....	5
Зураг 3. Нийт импорт.....	5
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	6

Зураг 5. Олон улсад зорчигч.....	6
Зураг 6. Орон нутагт зорчигч.....	6
Зураг 7. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар.....	7
Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	7
Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн боомтоор.....	8
Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор.....	9
Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар	10
Зураг 12. Автотээврээр зорчсон зорчигч.....	11
Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл.....	12
Зураг 14. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн.....	13
Зураг 15. Төмөр замын ачаа тээвэр, байгууллагуудын эзлэх хувь.....	14
Зураг 16. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	14
Зураг 17. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	14
Зураг 18. УБТЗ-ын ачаа тээврийн 7 дугаар сарын хоногийн мэдээ.....	14
Зураг 19. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	15
Зураг 20. Төмөр замын зорчигч тээвэр.....	16
Зураг 21. Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор.....	16
Зураг 22. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	17
Зураг 23. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	17
Зураг 24. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	17
Зураг 25. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	18
Зураг 26. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	18
Зураг 27. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	19
Зураг 28. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	20
Зураг 29. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	20
Зураг 30. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	21
Зураг 31. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	21

Боловсруулсан: Зам, тээврийн хөгжлийн яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа,
стандарт, статистикийн хэлтэс

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 7 дугаар сар

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ¹

Хүснэгт 1

Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт бууралтын % /Өссөн дүн/
			7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	6,083.0	35,758.8	7,337.7	49,220.3	37.6%
	Төмөр зам	мян.тн	3072.8	22,010.7	3,421.2	24,932.7	13.3%
	Агаар	мян.тн	0.58	4.66	0.93	5.52	18.6%
	Нийт ачаа	мян.тн	9,156.4	57,774.2	10,759.8	74,158.6	28.4%
Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	456.6	2,878.6	445.6	3,086.9	7.2%
Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	846.0	6,581.5	445.6	6,423.2	-2.4%
	Автотээвэр	мян.тн	5,880.4	34,656.2	7,114.7	47,792.5	37.9%
	Нийт	мян.тн	6,726.4	41,237.7	7,560.3	54,215.7	31.5%
Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	340.6	2,047.6	357.9	2,237.6	9.3%
	Автотээвэр	мян.тн	202.6	1,102.6	223.0	1,427.8	29.5%
	Нийт	мян.тн	543.2	3,150.3	580.9	3,665.4	16.4%
Дотоод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,429.6	10,514.1	1,660.3	13,177.0	25.3%
	Агаар	мян.тн	0.58	4.66	0.93	5.52	18.6%
	Нийт	мян.тн	1,430.2	10,518.8	1,661.3	13,182.6	25.3%
Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	8,687.7	80,156.8	9,519.6	82,686.9	3.2%
	Төмөр зам	мян.хүн	215.8	1,292.5	190.6	1,162.2	-10.1%
	Агаар	мян.хүн	214.8	923.2	270.6	1,200.5	30.0%
	Нийт зорчигч	мян.хүн	9,118.3	82,372.4	9,980.9	85,049.6	3.3%
Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	93.9	423.2	78.5	375.3	-11.3%
	Төмөр зам	мян.хүн	2.8	10.8	5.8	21.0	94.2%
	Агаар	мян.хүн	172.0	692.2	230.2	957.0	38.3%
	Нийт олон улсад зорчигч	мян.хүн	268.7	1,126.2	314.5	1,353.3	20.2%
Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	156.3	877.3	182.4	1,054.1	20.2%
	Төмөр зам	мян.хүн	213.0	1,281.6	184.8	1,141.2	-11.0%
	Агаар	мян.хүн	42.8	231.0	40.4	243.6	5.5%
	Нийт орон нутагт зорчигч	мян.хүн	412.1	2,389.9	407.7	2,438.9	2.05%
Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	8,437.5	78,856.3	9,258.7	81,257.5	3.0%
Олон улсын хөөрөлт, буултын тоо		ш	1,176	5,081	1,563.0	7,187.0	41.4%
Орон нутгийн хөөрөлт, буултын тоо		ш	1,436	5,551	1,373.0	5,971.0	7.6%
Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо		ш	4,163	21,124	6,052.0	36,740.0	73.9%
Авто замын боомтуудаар гарсан тээврийн хэрэгсэл		ш	72,864	379,328	73,589.0	480,837.0	26.8%
Авто замын боомтуудаар орсон тээврийн хэрэгсэл		ш	8,419	50,174	14,746.0	96,402.0	92.1%


¹ Зам, тээврийн салбарын 2024 оны 07 дугаар сарын статистикийн мэдээг урьдчилсан гүйцэтгэлээр “Салбарын нэгдсэн платформ”-оос нэгтгэн 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2024 оны 7 дугаар сард 10.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 17.5%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр буюу эхний 7 сард 74.2 сая тонн ачаа тээсэн нь өмнөх онтой харьцуулахад 28.4%-аар өссөн байна.


- 2024 оны 7 дугаар сард автотээврээр 7.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 20.6%-аар өссөн байна. Үүнээс экспортод 7.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21%-аар, импортоор 222.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 10.1%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Эхний 7 сар буюу өссөн дүнгээр нийт 49.2 сая тонн ачаа тээсэн нь 37.6%-аар, экспортын ачаа 47.8 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 37.9%-аар, импортын ачаа 1.4 сая тонн болж 29.5%-аар тус тус өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2024 оны 7 дугаар сард нийт 3.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 11.3%-аар өслөө. Үүнээс дотоодын ачаа 1.7 сая тонн болж өмнөх оны 07 дугаар сараас 16.1%-аар, импортын ачаа 357.9 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 5.1%-аар, экспортын ачаа 957.3 мянган тонн болж өмнөх оноос 13.2%-аар тус тус өссөн бол, дамжин өнгөрсөн ачаа 445.6 мянган тонн болж 2.4%-аар буурсан үзүүлэлттэй байна. Өссөн дүнгээр нийт 24.9 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 13.3%-аар, дотоодын ачаа 13.2 сая тонн болж 25.3%-аар, импортын ачаа 2.2 сая тонн болж 9.3%-аар, дамжин өнгөрсөн ачаа 3.1 сая тонн болж 7.2%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 6.4 сая тонн болж өмнөх онтой харьцуулахад 2.4%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 2024 оны 7 дугаар сард 925.5 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 59.4%-аар өссөн. Өссөн дүнгээр нийт 5,524 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.6%-аар өссөн байна. Үүнээс ачаа 5,398.1 тонн тээвэрлэсэн нь 31.7%-аар өссөн бол шуудан 125.8 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 76.9%-аар буурсан байна.

Зураг 1. Нийт ачаа тээвэр, мян.тонн



2024 оны 7 дугаар сард экспортоор 8.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 20%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр экспортын хэмжээ 54.2 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 31.5%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 6.4 сая тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.4%-аар буурсан бол автотээврээр 47.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 37.9%-аар өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 88%-ийг, төмөр зам 12%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2024 оны 7 дугаар сард нийт 580.9 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 6.9%-аар өссөн. Өссөн дүнгээр нийт 3.7 сая тонн ачаа импортлолсон нь өмнөх оны мөн үеэс 16.4%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 2.2 сая тонн ачаа импортлолсон нь 9.3%-аар, автотээврээр 1.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 29.5%-аар тус тус өссөн байна. Төмөр замаар импортын ачааны 61%-ийг, автотээврээр 39%-ийг тээсэн байна. /Зураг 3/





1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2024 оны 7 дугаар сард 9.9 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.5%-аар өссөн бол оны эхнээс өссөн дүнгээр 85 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр тэтгэврээр 2024 оны 7 дугаар сард 9.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9.6%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 78,504 зорчигч (-16.4%), орон нутагт 182,434 зорчигч (+16.7%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 9.3 сая зорчигч (+9.7%) тус тус зорчсон байна. Өссөн дүнгээр нийт 82.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.2%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 81.3 сая зорчигч (+3%), орон нутагт 1.1 сая зорчигч (+20.2%), олон улсад 375.3 мянган зорчигч (-16.4%) зорчжээ. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замаар 2024 оны 7 дугаар сард 190.6 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үеэс 11.7%-аар буурсан. Үүнээс олон улсад 5.8 мянган зорчигч зорчсон нь 2 дахин өссөн бол орон нутагт 184.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.2%-аар буурсан байна. Оны эхнээс өссөн дүнгээр нийт 1.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 10.1%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 21 мянган зорчигч зорчсон нь 94.2%-аар өссөн бол харин орон нутагт 1.1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 2024 оны 7 дугаар сард агаарын тээврээр нийт 270,626 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 26%-аар өссөн. Үүнээс олон улсад 230,185 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 33.8%-аар өссөн бол орон нутагт 40.4 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 5.5%-аар буурсан байна. Оны эхнээс өссөн дүнгээр нийт 1.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 30%-аар өссөн бол үүнээс олон улсад 956.9 мянган зорчигч зорчсон нь 38.3%-аар, орон нутагт 243.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 5.5%-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсад зорчигч

- Автотээвэр
- Төмөр зам
- Агаарын тээвэр

2024 оны эхний 7 сард олон улсад нийт 1.4 сая зорчигч (+20.2%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 957 мянган зорчигч (+38.3%), автотээврээр 375.3 мянган зорчигч (-11.3%), төмөр замаар 21 мянган зорчигч (+94.2%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 70.7%, автотээвэр 27.7%, төмөр зам 1.6%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2024 оны эхний 7 сард орон нутагт нийт 2.4 сая зорчигч (+2%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 1.1 сая зорчигч (+20.2%), төмөр замаар 1.1 сая зорчигч (-11%), агаарын тээврээр 243.6 мянган зорчигч (+5.5%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 10%, автотээвэр 43%, төмөр зам 47%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

2.1. АЧАА ТЭЭВЭР

2024 оны эхний 7 сард авто замаар нийт 49.2 сая тонн ачаа тээвэрлэснээс 47.8 сая тонн ачаа экспортолсон байна.


Хүснэгт 2

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нийт ачаа	тонн	6,083,029.0	35,758,828.0	7,337,700.0	49,220,313.5	37.6%
Ачааны импорт	тонн	202,594.0	1,102,639.0	222,992.0	1,427,811.9	29.5%
Ачааны экспорт	тонн	5,880,435.0	34,656,189.0	7,114,708.0	47,792,501.6	37.9%
Ачаа эргэлт	тн.км	938,077,237.0	5,561,263,098.5	1,010,909,392.0	6,885,713,078.9	23.8%

2024 оны 7 дугаар сард автотээвэрээр 7.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 20.6%-аар өссөн байна. Үүнээс экспортод 7.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21%-аар, импортоор 222.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 10.1%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 7 дугаар сард 1 тэрбум тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 7.8%-аар өссөн байна.

Сар бүр тээвэрлэсэн нийт ачааны хэмжээг зураг 7-д харуулав.


Зураг 7. Автотээвэрээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар



Эхний 7 сар буюу өссөн дүнгээр нийт 49.2 сая тонн ачаа тээсэн нь 37.6%-аар, экспортын ачаа 47.8 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 37.9%-аар, импортын ачаа 1.4 сая тонн болж 29.5%-аар тус тус өссөн байна. Ачаа эргэлт 6.9 тэрбум тонн км болж өмнөх оны мөн үеэс 23.8%-аар өссөн байна.

2024 оны эхний 7 сарын байдлаар нийт ачаа тээврийн 47.8 сая тонн буюу 97%-ийг экспортын ачаа, 1.4 сая тонн буюу 3%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Гашуунсухайт боомтоор экспортын ачааны 50.4%-ийг бүрдүүлж байна. Харин импортын ачааны 81.5%-ийг Замын-Үүд боомтоор оруулж ирсэн ачаа бүрдүүлж байна. /Зураг 8/

Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь




2.1.1. ЭКСПОРТЫН АЧАА, БООМТООР

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Хүснэгт 3 Өсөлт, бууралтын %
			7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа тээвэр	тонн	6,083,029.0	35,758,828.0	7,337,700.0	49,220,313.5	37.6%
2	Ачааны экспорт-боомтуудаар	тонн	5,880,435.0	34,656,189.0	7,114,708.0	47,792,501.6	37.9%
3	ОХУ-руу	тонн	7,239.0	95,353.0	3,711.0	24,043.1	-74.8%
4	Алтанбулаг	тонн	3,155.0	31,043.0	3,711.0	24,043.1	-22.5%
5	Боршоо	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
6	Цагаан нуур	тонн	4,084.0	64,310.0	0.0	0.0	-100.0%
7	БНХАУ-руу	тонн	5,873,196.0	34,560,836.0	7,110,997.0	47,768,458.5	38.2%
8	Бичигт	тонн	262,224.0	1,359,494.0	234,169.0	1,517,309.0	11.6%
9	Баянхошуу	тонн	23,037.0	644,721.0	39,317.0	257,628.6	-60.0%
10	Бургастай	тонн	3,258.0	139,738.0	30,844.0	309,363.3	121.4%
11	Булган	тонн	182,883.0	1,631,845.0	211,773.0	1,901,845.0	16.5%
12	Гашуунсухайт	тонн	3,408,662.0	19,115,023.0	3,441,189.0	24,106,608.6	26.1%
13	Замын-Үүд	тонн	21,363.0	534,533.0	191,482.0	1,163,812.0	117.7%
14	Ханги	тонн	268,932.0	2,579,531.0	584,147.0	4,574,686.0	77.3%
15	Хавирга	тонн	31,160.0	117,896.0	2,492.0	15,780.0	-86.6%
16	Шивээ хүрэн	тонн	1,671,677.0	8,437,896.0	2,375,584.0	13,921,426.0	65.0%
17	Сүмбэр	тонн	0.0	159.0	0.0	0.0	-100.0%

2024 оны 7 дугаар сард автотээврээр экспортод 7.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 37.9%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр экспортын ачаа 47.8 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 37.9%-аар өссөн байна. Үүнд Бургастай, Замын-Үүд, Шивээхүрэн, Ханги боомтуудаар уул уурхайн бүтээгдэхүүний ачаа тээвэр нэмэгдсэн нь нийт экспортын ачааны өсөлтөд голлон нөлөөлжээ.

Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор



■ 2024 оны эхний 7 сар ■ 2023 оны эхний 7 сар

ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 2024 оны 7 сард 3.7 мянган тонн (+17.6%) ачаа, харин өссөн дүнгээр 24 мянган тонн ачаа гарсан нь өмнөх оноос 22.5%-аар буурсан байна.

БНХАУ-тай хиллэдэг боомтоор 7 сард 7.1 сая тонн ачаа гарсан. Өссөн дүнгээр 47.8 сая тонн ачаа гарсан нь 38.2%-аар өссөн байна. Үүнээс хамгийн их ачаа Гашуунсухайт боомтоор 24.1 сая тонн (+26.1%) буюу нийт экспортын 50.4%-ийг дангаараа бүрдүүлж байна. Шивээхүрэн боомтоор 13.9 сая тонн (+65%), Ханги боомтоор 4.6 сая тонн (+77.3%), Булган боомтоор 1.9 сая тонн (+16.5%), Бичигт боомтоор 1.5 сая тонн (+11.6%), Замын-Үүд боомтоор 1.2 сая тонн (+117.7%), Бургастай боомтоор 309.4 мянган тонн (+121.4%), Баянхошуу боомтоор 257.6 мянган тонн (-60%), Хавирга боомтоор 15.8 мянган тонн (-86.6%) ачаа тус тус экспортод гарсан байна. /Зураг 9/

2.1.2 ИМПОРТЫН АЧАА, БООМТООР

Хүснэгт 4

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа тээвэр	тонн	6,083,029.0	35,758,828.0	7,337,700.0	49,220,313.5	37.6%
2	Ачааны импорт – боомтуудаар	тонн	202,594.0	1,102,639.0	222,992.0	1,427,811.9	29.5%
3	ОХУ-аас	тонн	31,612.0	192,098.0	27,124.0	230,160.9	19.8%
4	Алтанбулаг	тонн	15,067.0	98,179.0	16,771.0	117,535.9	19.7%
5	Боршоо	тонн	4,895.0	19,335.0	4,064.0	29,598.0	53.1%
6	Цагаан нуур	тонн	11,650.0	74,584.0	6,289.0	83,027.0	11.3%
7	БНХАУ-аас	тонн	170,982.0	910,541.0	195,868.0	1,197,651.0	31.5%
8	Бичигт	тонн	0.0	0.0	829.0	4,514.0	-
9	Баянхошуу	тонн	1,159.0	7,956.0	4,937.0	8,688.0	9.2%
10	Бургастай	тонн	0.0	20.0	0.0	280.0	1300.0%
11	Булган	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
12	Гашуунсухайт	тонн	0.0	851,950.0	0.0	0.0	-100.0%
13	Замын-Үүд	тонн	168,755.0	898,529.0	187,106.0	1,163,009.0	29.4%
14	Ханги	тонн	86.0	667.0	0.0	0.0	-100.0%
15	Хавирга	тонн	982.0	2,517.0	2,996.0	21,160.0	740.7%
16	Шивээ хүрэн	тонн	0.0	0.0	0.0	0.0	-

Автотээврээр 2024 оны 7 дугаар сард импортоор 222.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10.1%-аар өссөн байна. Үүнээс 27.1 мянган тонныг ОХУ-аас, 195.9 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн байна.


2024 оны эхнээс өссөн дүнгээр импортын ачаа 1.4 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 29.5%-аар өссөн байна. Үүнээс 230.2 мянган тонныг ОХУ-аас, 1.2 сая тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн байна.

Эхний 7 сард ОХУ-аас 230.2 мянган тонн, БНХАУ-аас 1.2 сая тонн ачаа оруулж ирсэн байна. Импортын ачааны 84%-ийг БНХАУ-аас, 16%-ийг ОХУ-аас оруулж ирсэн. **Нийт импортын ачааны 81.5%-ийг Замын-Үүд боомтоор оруулж байна.**

БНХАУ-аас Замын-Үүд боомтоор 1.163 мянган тонн ачаа (+29.4%), Хавирга боомтоор 21.2 мянган тонн ачаа (+740.7), Баянхошуу боомтоор 8.9 мянган тонн ачаа (+9.2), Бичигт боомтоор 4.5 мянган тонн ачаа тус тус оруулсан байна.

ОХУ-аас Алтанбулаг боомтоор 117.5 мянган тонн (+19.7%), Цагааннуур боомтоор 83 мянган тонн (+11.3%), Боршоо боомтоор 29.6 мянган тонн (+53.1%) ачаа тус тус орж иржээ. /Зураг 10/

Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор



Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 7 дугаар сар

2.1.3. АЧААНЫ НЭР ТӨРӨЛ


Хүснэгт 5

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нүүрс	тонн	5,773,630.1	32,977,065.8	6,803,734.0	45,708,982.0	38.6%
Газрын тос	тонн	23,037.3	316,002.2	39,316.8	257,627.8	-18.5%
Зэсийн баяжмал	тонн	52,840.0	401,320.0	84,549.7	563,811.7	40.5%
Төмрийн хүдэр	тонн	3,257.9	139,896.6	37,495.9	396,312.9	183.3%
Жонш	тонн	0.0	0.0	10,799.2	57,102.2	-
Бусад	тонн	27,669.7	884,102.1	138,812.4	738,771.4	-16.4%

Авто замын боомтоор гарсан ачааг нэр төрлөөр авч үзвэл нүүрс 7 дугаар сард 6.8 сая тонн (+17.8%), зэсийн баяжмал 84.5 мянган тонн (+60%), газрын тос 39.3 мянган тонн (+70.7%), төмрийн хүдэр 37.5 мянган тонн (*11), жонш 10.8 мянган тонн, бусад ачаа 138.8 мянган тонн ачаа гаргасан байна.

2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт нүүрс 45.7 сая тонн (+38.6%), зэсийн баяжмал 563.8 мянган тонн (+40.5%), төмрийн хүдэр 396.3 мянган тонн (+183.3%), газрын тос 257.6 мянган тонн (-18.5%), жонш 57.1 мянган тонн, бусад 738.8 мянган тонн ачаа тус тус экспортолсон байна. /Зураг 11/

Зураг 11 .Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар



2.1.4. АЧАА ЭРГЭЛТ, БООМТООР

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа эргэлт	тн.км	938,077,237.0	5,561,263,098.5	1,010,909,392.0	6,885,713,078.9	23.8%
2	Алтанбулаг	тн.км	419,106.0	2,972,106.0	471,086.0	3,256,315.9	9.6%
3	Бичигт	тн.км	20,977,920.0	108,759,520.0	18,799,840.0	121,745,840.0	11.9%
4	Баянхошуу	тн.км	15,485,440.0	417,713,280.0	28,322,560.0	170,442,624.0	-59.2%
5	Бургастай	тн.км	260,640.0	11,180,640.0	2,467,520.0	24,771,464.0	121.6%
6	Гашуунсүхайд	тн.км	783,992,260.0	4,396,651,238.5	791,473,470.0	5,544,519,978.0	26.1%
7	Замын-Үүд	тн.км	1,330,826.0	10,031,434.0	2,650,116.0	16,287,747.0	62.4%
8	Цагаан нуур	тн.км	1,573,400.0	13,889,400.0	628,900.0	8,302,700.0	-40.2%
9	Ханги	тн.км	5,380,360.0	51,603,960.0	11,682,940.0	91,493,720.0	77.3%
10	Шивээ хүрэн	тн.км	108,659,005.0	548,463,240.0	154,412,960.0	904,892,690.0	65.0%

2024 оны эхнээс өссөн дүнгээр автотээврийн ачаа эргэлт нийт 6.9 тэрбум тонн км ачаа болсон нь өмнөх оны мөн үеэс 23.8%-аар өссөн байна. Үүнээс ачаа эргэлт хамгийн их байгаа боомт болох Гашуунсүхайдгаар 5.5 тэрбум тонн км байгаа нь нийт ачаа эргэлтийн 80.5%-ийг дангаар бүрдүүлж байна.. /Хүснэгт 6/

2.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Автотээвэрээр 2024 оны эхнээс өссөн дүнгээр 82.7 сая зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 3.2%-аар өссөн байна.

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч тээвэр	<i>хүн</i>	8,687,675.0	80,156,801.0	9,519,638.0	82,686,885.0	3.2%
Олон улсад зорчигчид	<i>хүн</i>	93,891.0	423,206.0	78,504.0	375,291.0	-16.4%
Хот хоорондын зорчигч	<i>хүн</i>	156,290.0	877,296.0	182,434.0	1,054,129.0	20.2%
Хот доторх нийтийн тээвэрээр зорчигч	<i>хүн</i>	8,437,494.0	78,856,299.0	9,258,700.0	81,257,465.0	3.0%

Хүснэгт 7

Зураг 12. Автотээвэрээр зорчсон зорчигч



Автотээвэрээр 2024 оны 7 дугаар сард 9.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9.6%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 78,504 зорчигч (-16.4%), орон нутагт 182,434 зорчигч (+16.7%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 9.3 сая зорчигч (+9.7%) тус тус зорчсон байна.

Өссөн дүнгээр нийт 82.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.2%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээвэрээр 81.3 сая зорчигч (+3%), орон нутагт 1.1 сая зорчигч (+20.2%), олон улсад 375.3 мянган зорчигч (-16.4%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.5%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.2%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 12/

2.3. АВТО ЗАМЫН БООМТООР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

Авто замын боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
	7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
	81,283	429,502.0	88,335.0	577,239.0	34.4%
Орсон тээврийн хэрэгсэл	8,419	50,174.0	14,746.0	96,402.0	92.1%
БНХАУ-аас	7,152	39,072.0	11,274.0	78,387.0	100.6%
Бичигт	0	0.0	0.0	0.0	-
Баянхошуу	48	354.0	182.0	374.0	5.6%
Булган	44	595.0	0.0	0.0	-100.0%
Бургастай	0	3.0	0.0	9.0	200.0%
Гашуунсухайт	282	1,679.0	1,312.0	4,545.0	170.7%
Шивээхүрэн	105	324.0	1,084.0	22,905.0	6969.4%
Замын-Үүд	6,600	35,856.0	8,513.0	49,762.0	38.8%
Ханги	71	89.0	104.0	335.0	276.4%
Хавирга	28	198.0	79.0	457.0	130.8%
ОХУ-аас	1,267	11,102.0	3,472.0	18,015.0	62.3%
Алтанбулаг	1,066	6,800.0	1,075.0	7,307.0	7.5%
Боршоо	201	848.0	179.0	1,293.0	52.5%
Цагааннуур	0	3,454.0	2,218.0	9,415.0	172.6%
Гарсан тээврийн хэрэгсэл	72,864	379,328.0	73,589.0	480,837.0	26.8%
БНХАУ-руу	70,219	303,816.0	70,304.0	461,545.0	51.9%
Бичигт	3,642	3,642.0	3,374.0	13,201.0	262.5%
Баянхошуу	1,371	9,350.0	1,091.0	8,027.0	-14.1%
Булган	2,410	19,802.0	2,902.0	26,265.0	32.6%
Бургастай	121	2,619.0	678.0	9,435.0	260.3%
Гашуунсухайт	45,646	161,939.0	28,272.0	193,797.0	19.7%
Шивээхүрэн	12,902	67,105.0	19,014.0	109,862.0	63.7%
Замын-Үүд	443	3,181.0	8,758.0	49,832.0	1466.6%
Ханги	3,684	35,261.0	5,904.0	50,078.0	42.0%
Хавирга	265	1,179.0	311.0	1,048.0	-11.1%
Сүмбэр	0	3.0	0.0	0.0	-100.0%

Хүснэгт 8

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 7 дугаар сар

ОХУ-руу	2,645	75,512.0	3,285.0	19,292.0	-74.5%
Алтанбулаг	1,703	69,348.0	803.0	6,119.0	-91.2%
Боршоо	197	796.0	175.0	1,300.0	63.3%
Цагааннуур	745	5,368.0	2,307.0	11,873.0	121.2%

Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



Монгол Улсын авто замын боомтоор 2024 оны 07 дугаар сард нийт 88,335 ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бөгөөд үүнээс 14,746 тээврийн хэрэгсэл орсон нь өмнөх оны мөн үеэс 75.2%-аар, 73,589 тээврийн хэрэгсэл гарсан нь өмнөх оны мөн үеэс 1%-аар тус тус өссөн байна. /Хүснэгт 8/

Оны эхнээс өссөн дүнгээр нийт 577,239 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 34.4%-аар өссөн байна. Үүнээс орсон ачаа тээврийн хэрэгсэл 96,402 буюу 92.1%, гарсан тээврийн хэрэгсэл 480,837 болж өмнөх оны мөн үеэс 1%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 13/

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР
3.1. АЧАА ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2024 оны эхний 7 сард нийт 24.9 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх онтой харьцуулахад 23.3%-аар өслөө.


Хүснэгт 9

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Ачаа тээвэрлэлт	<i>мян.тн</i>	3,072.8	22,010.7	3,421.2	24,932.7	13.3%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	2,493.2	18,390.6	2,449.5	18,848.3	2.5%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	148.9	937.0	271.5	1,472.0	57.1%
"Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>	176.7	784.7	226.0	1,909.0	143.3%
"Монголиантранс Ложистик" ХХК	<i>мян.тн</i>	254.0	1,897.4	307.2	2,144.3	13.0%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>	0.0	0.0	166.9	689.1	-
Дотоодын ачаа	<i>мян.тн</i>	1,429.6	10,514.1	1,660.3	13,177.0	25.3%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	850.0	6,894.0	688.6	7,100.7	3.0%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	148.9	937.0	271.5	1,472.0	57.1%
"Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>	176.7	785.8	226.0	1,901.0	141.9%
"Монголиантранс Ложистик" ХХК	<i>мян.тн</i>	254.0	1,897.4	307.2	2,144.3	13.0%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>	0.0	0.0	166.9	689.1	-
Импорт ачаа	<i>мян.тн</i>	340.6	2,047.6	357.9	2,237.6	9.3%
Экспорт ачаа	<i>мян.тн</i>	846.0	6,581.5	957.3	6,423.2	-2.4%
Дамжин өнгөрөх ачаа	<i>мян.тн</i>	456.6	2,878.6	445.6	3,086.9	7.2%


Төмөр замын тээврээр 2024 оны 7 дугаар сард нийт 3.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 11.3%-аар өслөө. Үүнээс дотоодын ачаа 1.7 сая тонн болж өмнөх оны 07 дугаар сараас 16.1%-аар, импортын ачаа 357.9 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 5.1%-аар, экспортын ачаа 957.3 мянган тонн болж өмнөх оноос 13.2%-аар тус тус өссөн бол, дамжин өнгөрсөн ачаа 445.6 мянган тонн болж 2.4%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 9/

Өссөн дүнгээр нийт 24.9 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 13.3%-аар, дотоодын ачаа 13.2 сая тонн болж 25.3%-аар, импортын ачаа 2.2 сая тонн болж 9.3%-аар, дамжин өнгөрсөн ачаа 3.1 сая тонн болж 7.2%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 6.4 сая тонн болж өмнөх онтой харьцуулахад 2.4%-аар буурсан байна. /Зураг 14/

Зураг 14. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн




Зураг 15. Төмөр замын ачаа тээвэр, байгууллагуудын эзлэх хувь




Эхний 7 сарын байдлаарх нийт ачаа тээврийн 18.8 сая тонн буюу 75.6%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 2.1 сая тонн буюу 8.6%-ийн ачааг "Монголиантранс Ложистик" ХХК, 1.9 сая тонн буюу 7.7%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК, 1.5 сая тонн буюу 5.9%-ийн ачааг "Монголын төмөр зам" ТӨХК, 689.1 мянган тонн ачаа буюу нийт ачааны 2.8%-ийг "Монголиантранс Лайн" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 15/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 13.2 сая тонн буюу 52.9%-ийг дотоодын ачаа, 6.4 сая тонн буюу 25.8%-ийг экспортын ачаа, 3.1 сая тонн буюу 12.4%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 2.2 сая тонн буюу 9%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 16/

Зураг 16. Төмөр замын ачаа тээврийн төрөл



Зураг 17. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь



Дотоодод тээвэрлэсэн 13.2 сая тонн ачааны 7.1 сая тонн ачаа буюу 53.9%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 2.1 сая тонн ачаа буюу 16.3%-ийг "Монголиантранс Ложистик" ХХК, 1.9 мянган тонн буюу 14.4%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК, 1.5 сая тонн ачаа буюу 11.2%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 689.1 мянган тонн буюу 5.2%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 17/

Зураг 18. УБТЗ-ын ачаа тээврийн 07 дугаар сарын хоногийн мэдээ, 2024.07.01-2024.07.31




Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2024 оны 7 дугаар сар

“УБТЗ” ХНН-ийн ачаа тээврийн 7 дугаар сарын хоногийн мэдээг Зам, тээврийн салбарын нэгдсэн платформоос оруулав. /Зураг 18/

2024 оны 7 сард буюу 2024.01.01-ний өдрөөс 2024.07.31-ний өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг19/

Зураг 19 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор



Байгууллагуудын хоногт тээвэрлэх хүчин чадал буюу ачаа тээврийн хоногийн дундажийг эхний 7 сарын байдлаар тооцоход “УБТЗ” ХНН хоногт дунджаар 84.9 мянган тонн, “МТЛожистик” ХХК нь 10.1 мянган тонн, “ТТЗ” ХХК нь 8.9 мянган тонн, “МТЗ” ТӨХК нь 6.9 мянган тонн, “МТЛайн” ХХК нь хоногт дунджаар 3.2 мянган тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байна.


3.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Төмөр замаар олон улсад 2024 оны эхний 7 сард нийт 5.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 94%-аар өссөн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Зорчигч тээвэрлэлт	<i>мян.хүн</i>	215.8	1,292.5	190.6	1,162.2	-10.1%
Олон улс	<i>мян.хүн</i>	2.8	10.8	5.8	21.0	94.2%
Орон нутаг	<i>мян.хүн</i>	213.0	1,281.6	184.8	1,141.2	-11.0%
Зорчигч эргэлт	<i>сая хүн.км</i>	79.1	464.5	77.9	458.6	-1.3%

2024 оны 7 дугаар сард 190.6 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үеэс 11.7%-аар буурсан. Үүнээс олон улсад 5.8 мянган зорчигч зорчсон нь 2 дахин өссөн бол орон нутагт 184.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.2%-аар буурсан байна.

Зураг 20. Төмөр замын зорчигч тээвэр




Оны эхнээс өссөн дүнгээр нийт 1.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 10.1%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 21 мянган зорчигч зорчсон нь 94.2%-аар өссөн бол харин орон нутагт 1.1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11%-аар буурсан байна.

Орон нутгийн зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих мөн зорчигч вагоны тариф нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт төмөр замаар зорчигчдын 98% нь орон нутагт зорчсон бол 2% нь олон улсад зорчсон байна. /Зураг 20/

Зураг 21. Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор




2024 оны эхний 7 сар буюу 2024.01.01-ний өдрөөс 2024.07.31-ний өдөр хүртэл “УБТЗ” ХНН нь нийт 733.7 мянган зорчигч төмөр замаар тээвэрлэсэн байна. Эхний 7 сарын байдлаарх хоногийн дунжийг тооцоход төмөр замаар хоногт дунджаар 5218 зорчигч төмөр замаар зорчоод байна. /Зураг 21/

БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР
4.1 АЧАА ТЭЭВЭР

Хүснэгт 11

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа, шуудан тээвэр	тн	580.8	4,658.4	925.5	5,524.0	18.6%
2	олон улсад	тн	566.7	4,634.8	922.7	5,511.1	18.9%
3	орон нутагт	тн	14.0	23.6	2.8	12.9	-45.6%
4	Нийт ачаа	тн	554.9	4,100.1	912.0	5,398.1	31.7%
5	олон улсад	тн	553.8	4,091.8	909.2	5,385.4	31.6%
6	орон нутагт	тн	1.1	8.3	2.8	12.8	53.9%
7	Нийт шуудан	тн	13.1	545.5	13.5	125.8	-76.9%
8	олон улсад	тн	12.9	543.0	13.5	125.7	-76.8%
9	орон нутагт	тн	0.2	2.6	0.0	0.1	-96.5%




Агаарын тээврээр 2024 оны 7 дугаар сард 925.5 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 59.4%-аар өссөн. Үүнээс ачаа 912 тонн болж өмнөх оны 07 дугаар сараас 64.4%-аар, шуудан 13.5 тонн болж өмнөх оноос 2.8%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өссөн дүнгээр нийт 5,524 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.6%-аар өссөн байна. Үүнээс ачаа 5,398.1 тонн тээвэрлэсэн нь 31.7%-аар өссөн бол шуудан 125.8 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 76.9%-аар буурсан байна. /Зураг 22/


Оны эхнээс өссөн дүнгээр олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 5,511.1 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 18.9%-аар өссөн бол орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 12.9 тонн болж өмнөх оны мөн үеэс 45.6%-аар буурсан байна. /Зураг 23/

Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.8%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.2%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 97.7%-ийг ачаа эзэлж байгаа бол 2.3%-ийг шуудан эзэлж байна.

Зураг 23. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан



Зураг 24. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар



4.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт 1.2 зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 30%-аар өслөө.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Хүснэгт 12 Өсөлт, бууралтын %
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч тээвэр	<i>хүн</i>	214,814	923,164.0	270,626	1,200,537	30.0%
Олон улсад	<i>хүн</i>	172,008	692,198.0	230,185	956,992	38.3%
Орон нутагт	<i>хүн</i>	42,806	230,966.0	40,441	243,565	5.5%




2024 оны 7 дугаар сард агаарын тээврээр нийт 270,626 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 26%-аар өссөн. Үүнээс олон улсад 230,185 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 33.8%-аар өссөн бол орон нутагт 40.4 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 5.5%-аар буурсан байна.

Оны эхнээс өссөн дүнгээр нийт 1.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 30%-аар өссөн бол үүнээс олон улсад 956.9 мянган зорчигч зорчсон нь 38.3%-аар, орон нутагт 243.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх онтой харьцуулахад 5.5%-аар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 12/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэн нь харагдаж байна./Зураг 26/

Зураг 26. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар




4.2.1. ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Хүснэгт 13


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралт %
			7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт зорчигч тээвэр	<i>хүн</i>	214,814	923,164.0	270,626	1,200,537	30.0%
2	Олон улсад	<i>хүн</i>	172,008	692,198	230,185	956,992	38.3%
3	чиглэл Сөүл	<i>хүн</i>	81,889	315,260	94,956	349,593	10.9%
4	Токио	<i>хүн</i>	10,809	53,930	16,029	69,416	28.7%
5	Франкфурт	<i>хүн</i>	11,160	32,989	12,686	44,437	34.7%
6	Истанбул	<i>хүн</i>	15,044	76,914	16,304	83,364	8.4%
7	Бээжин	<i>хүн</i>	14,943	55,831	30,757	146,906	163.1%
8	ХонКонг	<i>хүн</i>	9,191	33,126	12,427	52,732	59.2%
9	Гуанжоу	<i>хүн</i>	2,325	4,796	1,950	8,345	74.0%
10	Бусан	<i>хүн</i>	11,728	31,465	11,814	38,841	23.4%
11	Осака	<i>хүн</i>	2,222	2,222	2,206	2,206	-0.7%
12	Тэгү	<i>хүн</i>	365	365	3,786	5,115	1301.4%
13	Алмата	<i>хүн</i>	1,675	9,633	2,126	11,327	17.6%
14	Эрхүү	<i>хүн</i>	1,747	6,502	2,411	10,333	58.9%
15	Хөх хот	<i>хүн</i>	473	4,363	5,116	26,304	502.9%
16	Чэжү	<i>хүн</i>	773	1,124	1,926	3,478	209.4%
17	Чонжү	<i>хүн</i>	403	403	3,517	6,758	1576.9%
18	Санья/Хайнань	<i>хүн</i>	0	41	1,408	5,233	12663.4%
19	Манжуур	<i>хүн</i>	1,099	3,828	983	7,143	86.6%
20	Муан	<i>хүн</i>	3,131	3,131	4,093	9,937	217.4%
21	Хайлаар/Хөлөнбуйр	<i>хүн</i>	718	1,160	1,701	12,899	1012.0%

2024 оны эхнээс өссөн дүнгээр олон улсад нийт 956.9 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн 38.3%-аар өссөн. Сөүл чиглэлд мянган зорчигч 349.6 (+10.9%), Бээжин хот руу 146.9 мянган зорчигч (+163.1%), Истанбул хот руу 83.4 мянган зорчигч (+8.4%), Токио чиглэлд 69.4 мянган зорчигч (+28.7%), Бусанруу 38.8 мянган зорчигч (+23.4%), ХонгКонг-руу 52.7 мянган зорчигч (+59.2%), Франкфурт чиглэлд 44.4 мянган зорчигч (+34.7%), Хөх хотруу 26.3 мянган зорчигч (+502.9%), Хайлаар/ Хөлөнбуйр чиглэлд 12.9 (*100), Гуанжоу чиглэлд 8.3 (+74%), Алмата хотруу 11.3 (+17.6%), Эрхүү хотруу 10.3 (+58.9%), Манжуур хотруу 7.1 (+86.6%), Муан чиглэлд 9.9 мянган зорчигч (+217.4), Хайнань руу 5.2 мянган зорчигч тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 27/

Зураг 27. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



Зураг 28. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр эхний 7 сард олон улсад 454,995 мянган зорчигч зорчсон бол “Korean Air”-ийн нислэгээр 84.2 мянга, “Airchina”-ийн нислэгээр 82.3 мянга, “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 72.5 мянга, “Туркиш эйрлайнс” ХХК-ын нислэгээр 50.1 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 54.3 мянга, “Изинис Эйрвейз” ХХК-ийн нислэгээр 13.1 мянга, Жэжү айр нислэгээр 48.3 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 37.5 мянга, Ираеро нислэгээр 9.7 мянган зорчигч, Айр Бусан нислэгээр 9 мянга, Красавиа нислэгээр 1.4 мянга, захиалгат нислэгээр 1.1 мянган зорчигч зорчсон байна. /Зураг 28/

4.2.2. ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Хүснэгт 14

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
			7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт зорчигч тээвэр	хүн	214,814	923,164	270,626	1,200,537	30.0%
2	Орон нутагт зорчигч тээвэр	хүн	42,806	230,966	40,441	243,565	5.5%
3	чиглэл Ховд	хүн	1,407	5,628	1,673	8,555	52.0%
4	Улаангом	хүн	754	1,763	1,075	3,354	90.2%
5	Алтай	хүн	322	358	1,169	5,352	1395.0%
6	Оюутолгой	хүн	30,027	204,631	27,051	200,921	-1.8%
7	Оюутолгой/Даланзадгад	хүн	0	0	0	457	-
8	Мөрөн	хүн	3,751	5,190	4,568	7,827	50.8%
9	Өлгий	хүн	2,281	5,484	1,742	6,442	17.5%
10	Улиастай	хүн	1,080	2,989	842	3,848	28.7%
11	Даланзадгад	хүн	2,565	3,303	2,321	5,502	66.6%
12	Мөрөн/Улаангом	хүн	0	0	0	1,021	-
13	Бусад	хүн	0	0	0	286	-


Зураг 29. Орон нутгийн зорчигч, чиглэлээр



2024 оны 7 дугаар сард орон нутагт нийт 40.4 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 5.5%-аар буурсан байна.

Оны эхнээс өссөн дүнгээр орон нутагт нийт 243.6 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.5%-аар үзүүлэлттэй байна. Оюутолгой чиглэлд нийт 200.9 мянган зорчигч тээвэрлэсэн нь 1.8%-аар буурсан үзүүлэлттэй байна. Орон нутгийн бүх чиглэл тэр дундаа Алтай, Улаангом, Даланзадгад чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн байна. /Хүснэгт 14/

Зураг 30. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



2024 оны эхний 7 сард агаарын тээврээр орон нутагт зорчигчдын 66% буюу 159.8 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 19% буюу 46.9 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 15% буюу 36.8 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутагт “МИАТ” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 39.2%-аар өссөн бол “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 21.4%-аар, “Аэро Монголиа” ХХК зорчигч 32.2%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 30/

4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

Хүснэгт 15

Үзүүлэлт	2023 он		2024 он		Өсөлт, бууралтын %
	7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нийт нислэгийн тоо	6,775	31,756.0	8,988	49,898	57.1%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	4,163	21,124.0	6,052	36,740	73.9%
Хөөрөлт, буулт	2,612	10,632.0	2,936	13,158	23.8%
Олон улсын хөөрөлт, буулт	1,176	5,081.0	1,563	7,187	41.4%
Орон нутгийн хөөрөлт, буулт	1,436	5,551.0	1,373	5,971	7.6%

2024 оны 7 дугаар сард нийт нислэгийн тоо 8,988 болж өмнөх оны мөн үеэс 32.7%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 6,052 болж өмнөх оны мөн үеэс 45.4%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт буулт 1,563 болж 32.9%-аар өссөн бол орон нутгийн хөөрөлт, буултын тоо 1,373 болж 4.4%-аар буурсан байна.

2024 оны эхнээс өссөн дүнгээр нийт нислэгийн тоо 49,898 болж өмнөх оны мөн үеэс 57.1%- аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 36,740 болж өмнөх оны мөн үеэс 73.9%-аар, олон улсын хөөрөлт, буултын тоо 7,187 болж 41.4%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 5,971 болж өмнөх оны мөн үеэс 7.6%-аар тус тус үзүүлэлттэй байна. /Зураг 31/

Зураг 31. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

